

ЗУРХАЙ, ТҮҮНИЙГ ТОЙРСОН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Д.Даваасүрэн МБШТөв, Гандантэгчэнлин хийдийн шавь, МБШИС-ийн багш

Түлхүүр үгс: Шашны зурхай, Пүг ёс, Цүр ёс, Судрын ёс, Хүмүүний ёс, Амны эш, Цаг тооны бичиг, Монгол зурхай

Өчил Юуны өмнө "мэдэхгүйгээ мэднэ хэмээн омойтож, мэдэх, чадахаас нь үл асуугч", "үргэлжид ном бусын явдлаар алмайтан, согтуурагч" миний бие мэдэх юм үнэхээр үгүйгээ олон мэргэдийн өмнө хүлцэн өчье.

Гэвч, дахин давтан олохуй яа нэн бэрх чөлөө, учралт хүмүүний бие их эрдэнийг эрхшээн, зөв, ариун ном сургаал лугаа учирсан сайн золыг өчүүхэн олсоны тул "омойтон" сагсуурч, барьж тавин их л назгай судлан үзэж, хэсэг бусаг сэтгэлийн толионд бэдэртсэн дуулсан эрдэм, уншсан номоосоо уншигч тантай хуваалцаж байгаа даа баяртай байна.

Энд гагц миний үгээр дүүрсэн болох бөгөөс ухаан сохор дэмий чалчаад нэн дурлагч нэгэн боловч сатааран сонсож, хэрэгсэхийн аргагүй согтуу галзуугийн үг болох нь эргэлзээгүй боловч, урьдны мэргэдийн таалсан ёс, туурвисан бүтээлээс түүвэрлэн авч, өөрийн чадлын хэрээр таалал ёсонд нь тулган, найруулж, эмхэтгэсэн учираа Та бүхний алтан сонорт унагаж, цээжин дотроо хадгалж, цэгнэж явдаг хувийн бодлоо дашрамд нь уламжлая.

Өгүүлэлд ашигласан эх сурвалжийн тухай

Энэхүү өгүүлэлд Өндөр гэгээний Өвгөн хийд, эдүгээ цагийн Шанхын Баруун хүрээний гавж Тэгчэндоржийн 1923, 1929 онд тус тус бичсэн "Шашны зурхай" хэмээх зохиолд тулгуурлан, түүнээс татан авч хэрэглэсэн зарим нэг он тоолол, цаг хугацааны асуудлыг 1760 онд Лхүндүв бандидын зохиосон "Шашны зурхай эрдэнийн эрхи" хэмээх зохиолтой харьцуулан баталж бэлтгэсэн болно.

Тэгчэндоржийн "Шашны зурхай" хэмээх эл хоёр бүтээл нь бард гараагүй, гар бичмэл бөгөөд зохиогчийн өөрийн гар бичмэл гэж үзэх бүрэн үндэслэлтэй байгаа юм. Тэгчэндоржийн нэг боть гар бичмэл зохиол эдүгээ Өндөр гэгээн Занабазарын нэрэмжит Монголын Бурханы Шашны Их Сургууль (цаашид МБШИС хэмээн товчлоно.)-ийн номын санд хадгалагдаж байгаа болно.

МБШИСургуулийн 30 жилийн ойгоор, 2000 онд хэвлүүлэн гаргасан Лхүндүв бандидын "Шашны зурхай эрдэнийн эрхи"-ийн түвэд эхийн хавсралтаас харж, ихэд алдартай энэхүү эх сурвалжийг баталгаа болгон ашиглалаа.

Пүг, Цүр ёс хийгээд Монголчууд Тэгчэндорж гавж уг номынхоо эхэнд "Бурханы мэндэлсэн жил тэргүүтэнд олон мэргэдийн таалал ёс адилгүй. Гэвч, бидний гэ-лүг-ба нар дагадаг Будон гэгээн болон Хайдүб-жэ гэгээний таалал, бас олноо ихэд алдаршсан <<Пүг>> хэмээх хоёр ёсонд тулгуурлан өчүүхэн өгүүлбэ" [1. 1х, 4-6 мөр] хэмээсэн бол Ордосын Лхүндүв бандида:

"Итгэлт түүний мэндэлсэн жил тэргүүтэн шашны зурхайн аймагт

Ивгээлт олон мэргэдийн таалах ёс адилгүй олон ч

Би бээр Будон ёсыг даган баримтладаг боловч

Бүхэнд дуурсахын тул <<Амны эш>>-ийн ёс адил өгүүлье" [2. 135тал., 5-7 мөр] хэмээснээс дүгнэхэд дээрх эх сурвалжууд нь "Пүг" ёс буюу Пүгба Лхүндүвжамцын зохиолыг баримтлан бичсэн нь илэрхий байна.

Монгол газрын хуваарьт тохируулан бодож боловсруулсан "төгс буянт"-ын шинэ зурхайг үндэслэгч ламын гэгээн Лувсанданзанжанцан <<Зурхайн гол авч, огоорохыг тодотгогч гэрэл>> хэмээх бүтээлээ "Жову Адишаагийн таалал ёсоор хөтөлсөн" болохыг доктор, профессор, зурхай судлаач Л.Тэрбиш номондоо тэмдэглэсэн байна. [3. 8тал, 5-6 мөр] Энэ мэт харилцан адилгүй, ямар нэг хэргийн тухайд пүг болон цүр ёсны аль нэгийг голлон авч хэрэглэсэн жишээ баримтыг дурдваас олныг өгүүлэх хэрэг гарах нь тодорхой. Ер нь өргөн олны дунд, тэдний хэрэглээ, шаардлагат нийцүүлэн Бурханы шашин орших зэрэг тодорхой үйл явдлуудтай холбоотой хугацааг авч үзэхдээ Сударын болон Тарнийн ёсоос **Судрын ёсыг**, нийтийн бусын цаг хугацааг тоолох ёс Цагийн хүрдэний болон, нийтийн ёсны цаг хугацааг тоолох ёс Хүмүүний ёс хоёроос **Хүмүүний ёсыг** онцлон авч үздэг нь эргэлзээгүй юм.

Үүний нэгэн адил ямар тохилдолд нь монголчууд пүг ёс, цүр ёсоос сонгон авч хэрэглэж байсныг судлан тодруулах шаардлага байхыг үгүйсгэхгүй бөгөөд үүнд газар зүйн байршил, тухайн орон нутгийн хурал номын онцлог, дэг жаяг, хүмүүний ахуй амьжиргааны хэв маяг хүртэлх олон хүчин зүйл нөлөөлж байв уу гэдгийг нягтлах хэрэгтэй юм.

Эцэст нь тэмдэглэхэд пүг эсвэл цүр ёс гэх нь зурхайн бодолтын хуучин ба шинэ, саасан, эс саасны ялгааны тухай асуудал болохоос агуулгын хувьд илэрхий зөрөөтэй, өдөр шөнө шиг ойлголт биш. Бидний дээд үеийн монгол номын мэргэд бүтээл туурвилынхаа эхэнд "Будон гэгээн болон Хайдүб-жэ гэгээний таалал, бас олноо ихэд алдаршсан <<Пүг>> хэмээх хоёр ёсонд тулгуурлан" гэх юм уу, "Би бээр Будон ёсыг даган баримтладаг боловч, бүхэнд дуурсахын тул <<Амны эш>>-ийн ёс адил өгүүлье" зэргээр чухам хэний тааллыг дагасанаа заавал нэр заан тэмдэглэдэг байсан нь үүний баталгаа болно. Тиймээс хоёр ёсоос аль нэгийг нь сонгон авсан, эсвэл тэдгээрийн дагуу бодолт хийхэд зарцуулсан хугацааны их, багадаа ч гол нь биш. Гагцхүү эцсийн дүнд мадаггүй, эс бөгөөс мадагтай бодсоноос бүх зүйл шалтгаалах нь тодорхой байна.

Зурхайн ухаанд, ялангуяа монгол газрын хуваарь, ард олны амьжиргааны онцлогт таарсан төгс буянт шинэ зурхайд шамдан суралцах, сургах замаар нягтлан, судлах үүргийг хэн хэн хүлээх вэ?...Энэ нь мэдээж хэрэг, сүүлийн нэгэн жаран гарангийн хугацаанд зурхайнхаа бодолтыг шинчилж, засаж явах нь битгий хэл уламжлалт шашин, өв соёлоо нүд үзүүрлэж, хөгжлийн бодлогынхоо гадна орхисон өнөөгийн бидний хувьд томоос том, бэрхээс бэрх асуудал. Гэвч, өнөөгийн бид л үүнд хариуцлагатай хандаж, асуудлыг нэг мөр болгон шийдэх үүрэгтэй. Ингэж эс чадваас нэгэнт балрах шахталаа өвөө устгуулсан "Монгол зурхайчийн удам тасарч, хүн төрөлхтний түүхэн дэхь Монголын оюуны соёлын гайхамшиг, түүний нууц зөвхөн цааснаа үлдэх вий" гэсэн эмзэглэл төрдөг юм.

Учир иймээс шашны болон шинжлэх ухааны зүтгэлтэнгүүд энэ тал дээр хамтран гарц хайж, ойрын ирээдүйд жинхэнэ зурхайн ухаанд мэргэшсэн

боловсон хүчин бэлтгэж чадсанаар үүнд бүрэн дүүрэн хариултыг өгөх боломжтой юм.

Зурхай, түүнийг тойрсон асуудлууд.

Бурханы шалгадаг ухааны охь шимээс ундарсан тунгалаг мэдэгдэхүүний орны нэг бол зурхайн ухаан юм. Тиймээс зурхайг бусад ухааны орны нэгэн адил "хамаг амьтны энэ насны тус, хожим хойчийн амгаланг бүтээхийн тулд" хэрэглэдэг.

Бидний өвгөд дээдэс өдөр тутмын ахуй амьдралдаа зурхайг хэрэглэж байсны нэгэн том гэрч бол "Цаг тооны бичиг" боловсруулан хөтөлж байсан уламжлал бөгөөд 1911 оноос өмнө Чин улс 270 гаруй жил хэрэглэсэн "Цагийн дүрмийн зурхай", үүнээс өмнө Юань улсын үед 400-аад жил хэрэглэсэн "Цагийн мэдээгийн зурхай", түүний дараа Мин улсын үед хэрэглэж байсан "Хотол их зурхай" гэх мэтийг энд холбогдуулан дурдаж болно. [4.]

Тэгээл одоо бидэнд нийтээр дагаж мөрдөхөөр хүлээн зөвшөөрсөн дээрх мэт "Цаг тооны бичиг" байна уу? Ийм цаг тооны бичигтэй болох шаардлагатай юу?

Хоёр дахь асуултанд нь эхлэж хариулъя. Жил болон жарнаар зохиож, цаг агаарын байдлыг нарийн шинжилж нүүдлийн болон суурин хот хүрээнийхний өдөр тутмын амь амьжиргаанд тус нэмэр болж, цаг, өдөр, сар, жилээр болон нэгэн насаар тооцож хувь төөргийг нь зурах, байгаль зэрэг харилцааны бусад оронтой зөв зохистой харьцах хэм хэмжээг тогтоож өгч чадах дээд түвшний цаг тооны бичиг өнөөдөр нэн чухал хэрэгтэй байна.

Одоо нэг дэх асуултанд хариулт өгье. Доорхи хоёр шалтгааныг үндэслэн байхгүй гэж хариулахыг миний бие хүсч байна. Ингэхдээ ард түмэн нийтээр "Тэрбишийн зурхай" хэмээн нэрлэдэг цаг тооны бичгийг байхгүйд гүтгэсэн хэрэг биш. Энэ дашрамд тэмдэглэхэд, доктор, профессор Л.Тэрбиш нь шашин ном хаалттай бэрх цагт шамдлагыг үүсгэн, ламын гэгээн Лувсанданзанжанцан тэргүүтнээс дамжлага нь тасралтгүй уламжлагдаж ирсэн монгол зурхайг өөрийн багш Жинба, гандан хийдийн зурхайч Галсанравжаа зэрэг мэргэдээс өөлөн, монгол орны өнцөг булан бүрээс зурхайн ном судрыг цуглуулан хадгалан авч үлджээ. Тиймээс өнөө цагт төр соёрхон баталваас зохих цаг тооллын бичиг бол түүний эрхлэн гаргадаг цаг тооны бичиг мөн юм. Энэхүү цаг тооны бичиг нь зөвхөн Л.Тэрбишийнх ч биш, үе үеийн монголчуудын оюуны соёлын өв билээ.

Нэгдүгээрт, төр нь соёрхож, түмэн олон нь хүлээн зөвшөөрсөн цаг тооны бичиг одоо хэр нь алга.

Хэрэв уламжлалт шашин соёлоо дээдэлж, өвгөд дээдсийнхээ мэдлэг ухааныг эрхэмлэн, тэдгээрийг залуу хойч үеэ соён гэгээрэх нэг эх булаг гэж үздэг төртэй л бол даруй зайлшгүй анхаарч үзэх ёстой зүйл нь энэ мөн.

Хоёрдугаарт, иргэдийн цаг тооны бичиг хэрэглэх зэрэг хэрэгцээ шаардлагыг зарим хүмүүс ашиг орлого олох зам болгон ашиглах явдал ихээхэн түгээмэл боллос.

Үүний нэг баримт нь "Чингисийн шар зурхай" гэх огторгуйн цэцэг адил оргүйгээс гарсан цаг тооны бичиг мөн. Оюуны болоод бусад соёлын өвөөрөө Дэлхийн улс гүрнүүд "түшилдэх" болсон XXI зуунд цаашид ийм байдалтай яавч байж болохгүй санагдана. Үгийн далимд "Чингисийн тухай зөв буруу хичнээн ярьсан ч, Чингис бүдгэрэхгүй. Харин тэд өөрсдөө хэтэрхий бүдгэрчих вий" гэсэн Даваанямтангуудад (Чингис хааны дэлхийн академийн

ерөнхийлөгч) хандаж хэлсэн ардын уран зохиолч Б.Лхагвасүрэн гуайн үгийг энд зориуд сийрүүлэхийг хүсч байна.

Энэ санаагаараа би, цаг тооны бичгийг олон янзаар олшруулан түгээхийг буруушаагаагүй. Цаг тооны бичиг гаргах, түгээх эрхийг ганц хүнд хамааруулах гэсэн явдал бүр биш. Бодолтын хувьд нэгэнт байгаа, өдий болтол хэрэглэсээр ирсэн монгол газрын хуваарьт тохирсон төгс буянтын ёсыг бүгдээрээ баримтлах нь зөв. Харин цаг тооны бичиг эрхлэн гаргагчид нэг нэгнээсээ ялгарахын тулд эмнэлэг, газар тариалан, аялал жуулчлал гэх мэт салбарт тухайлан зориулсан байдлаар доторхи хавсралтаар өгч байгаа мэдээллээ бэлтгэж, өөрийн гэсэн онцлогоо бүрдүүлчихвэл болчих юм биш үү гэж хэлэх гэсэн юм. Булаацалдаад байхааргүй олон салбар бидэнд байна шүү дээ.

Энэ явдлыг төрийн болон Бурханы шашны дээд байгууллагын шууд оролцоотойгоор цэгцэлж, "Эрт, орой шинэллээ", "Тэр алдлаа", "Би онолоо" гэж өвөр зуураа хөлөө жийлцэх явдлыг нэг мөр ингэж эмхэлвэл иргэний сэтгэл зүйд ч ихээхэн ашигтай болохсон.

Энэ мэтээр нэгэнт бий болоод байгаа сөрөг үйл явцыг зөвөөр залах боломж нөхцлийг бидэнд өнөөгийн нийгэм бий болгож өгсөн. Гэвч, энэ таатай цаг мөчийг бид бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байна.

Аливаа шашин орших, дэлгэрэх нь түүний гүн ухаан хэр дэлгэрч байгаагаас шууд хамаардаг, түүгээр хэмжигддэг болох талаар МБШТөв, Гандантэгчэнлийн хийдийн Дашчойнпэл дацангийн шүнлайв гавж С.Гантөмөр "Билгийн мэлмий" сонинд өгсөн ярилцлагандаа онцолсон байдаг. Тиймээс ч, МБШТөвөөс бусад ухааны орноос хувь илүүтэйгээр цанид чойрын сургалтанд анхаарал хандуулж, гадаад дотооддоо залуу лам нарыг бэлтгэсээр байна.

Харамсалтай нь 1991 онд байгуулагдсан Монголын Бурханы Шашинтны Төв (цаашид МБШТ гэж товчилно.) болон Гандантэгчэнлин зэрэг томоохон хийдээс өнгөрсөн хорь шахам жилийн хугацаанд нэг ч ламыг зээрэмбэ болгохоор албан ёсоор бэлтгээгүй байх юм. Өдөр тутмын амьдралдаа энгийн ямар ч хүн гүн ухааныг ашиглахаасаа урд эмнэлэг, зурхайг илүү ашигладаг гэдэг нь хэнд ч тодорхой биш гэж үү.

Ингэж хэлсэнээрээ гүн ухааны сургалтыг үл тоож байгаа хэрэг биш бөгөөд их бага ухааны орон нийтэд анхаарлаа хандуулж, бодлоготой хөгжүүлээсэй гэж хүссэн хэрэг юм.

Ингэхийг биднээс цаг үе шаардаж байна гэж би үзэж байгаа билээ. Учир нь **нэгд**, харийн шашны урсгал хүчтэй орж ирэх болсон дотоод нөхцөл шалтгааны улмаас, **хоёрт**, үндэсний дархлаа болсон оюуны болоод эдийн өв соёлоо бүрэн утгаар нь үе, гишүүнтэй нь нэн хурдан хэн сэргээж, уламжлан авч чадна тэр дэлхийн түүхийн тавцанд содрон үлдэж, эс чадсанд нь мөхөл зайлшгүй ирэх гадаад нөхцөл шалтгаан буюу дэлхийн түүхийн маш хариуцлагатай үед бид амьдарч байна.

Бурхан багш нирваан дүр үзүүлээд хэдэн жил болсон бэ

Үндэсний онцлог, зан заншил, сэтгэлгээнд нэвт шингэн уламжлагдсан Бурханы шашинтай тусгаар тогтносон улсын хувьд олон зүйл дээр өөрийн гэсэн тодоос тэд байр суурь, бодлоготой хандах ёстой хэмээн бодож явдаг хүний хувиас доорхи эх сурвалжийн мэдээг эш татан цухас сийрүүлэхийг хүссэн юм.

Энэ 2007 оны улаагчин гахай жил Хиндү ёсыг баримтлаж, Бурхан багшийн нирваан дүр үзүүлсний 2550 жилийн ойг бид ёслон тэмдэглэсэн. Гэвч энэ нь 2550 жил үү, эсвэл 2551 жил үү гэдэг нь бас л маргаантай байлаа. Үүгээр зогсохгүй "мэндэлсэн" эсвэл "нирваан" дүр үзүүлсэн алин болохыг ч мэдэхгүй хутган ярих тохиолдол байсан нь нэн харамсалтай.

Бурхан багшийн лагшин мэндэлсэн он цагийн тухай Тэгчэндорж гавж "пүг ёсонд бид нарын багш Шагжаан хаан бээр "Хатуу" хэмээх цагаан Бичин жилийн зуны эхэн Сага сарын шинийн долооны өдөр мэндэлсэн. Эдүгээ арванзургаа дугаар жарны 13 дахь шарагчин Могой (1929 он) жилд хоёр мянга найман зуун ерэн жил (2890) өнгөрчээ" [1. 1х, 6-7 мөр], Лхүндүв бандида "Маха-маяагийн хэвлийд шарагчин хонин жилийн Бурвасад сарын битүүнд оршиж, түүний хойд цагаан бичин жилийн Сага сарын шинийн долоонд, Лхүнбүний цэцэрлэгт лагшин мэндэлсэн болой" [2. 135тал., 10-12 мөр] хэмээжээ.

Энэ дагуу үзвэл, эдүгээ Бурхан багш мэндлээд 2969 жил, 81 настай цагаан луу жил таалал болсон гэж үзвэл 2888 жил өнгөрсөн болно.

Тэгвэл ламын гэгээн Лувсанданзанжанцан "Зурхайн гол авч, огоорохыг тодотгогч гэрэл"-ийн төгсгөлийн үгэндээ "...Бурхан багшийг мэндэлсэнээс хойш 2642 жил өнгөрсөн арванхоёр дугаар жарны гал туулай жил (1687 он)-ийн арван 11 дүгээр сард..." [3. 9тал., 34-36 мөр] хэмээн зохиолоо эхлүүлсэн болон дуусгасан тухай мэдээ дурдсан байдаг байна. Эндээс хөөж үзэхэд эдүгээ Бурхан багш мэндлээд Жову жэ гэгээний ёсоор 2962 жил болж таарна.

Бас Тэгчэндорж гавж 1923 он буюу арвантав дугаар жарны харагчин гахай жил бичсэн "Шашны зурхай" -даа Халхын анхдугаар Богд, Өндөр гэгээн Занабазар буюу Лувсанданбийжанцан нь арван нэгдүгээр жарны 9 дэхь хөхөгчин гахай жил (1635 он) мэндэлсэн хэмээгээд эдүгээ 289 жил болов [1. 3хуудас "А"тал, 5-6 мөр] хэмээн тэмдэглэсэн. Энэ нь мөн тэнд дурдсанаар аравдугаар жарны 54 дэхь төмөр бичин жил (1620 он) "Самадийн бүлэг"-ийн үргэлжлэх хугацаа төгсвөр болж "Шагшаавадын бүлэг" эхлээд даруй 16 жил өнгөрсөн хөхөгчин гахай жил мөн [1. 3хуудас "А"тал, 4-5 мөр] болохыг тодруулсан байна.

Лхүндүв бандида Шагшаавадын бүлгийн үргэлжлэх хугацааг "10 дугаар жарны төмөр Бичээс 19 жарны шороон Туулай хүртэл 500 жил Шагшаавадын бүлэг бөгөөд бүтээлийн таван зуугийн доод гурвын үе болой" [2. 157тал., 9-10 мөр] хэмээсэн нь Шагшаавадын бүлгийн эхлэх хугацааны хувьд "төмөр бич" гэсэн нь таарч байгаа юм.

Энэ дагуу үзвэл, эдүгээ Судрын ёсоор Бурханы шашны Шагшаавадын бүлэг эхлээд 387 жил, Өндөр гэгээн Занабазар мэндлээд 373 жил болж байгаа нь бидний баримталж байгаатай таарч байна.

Одоо бидний баримтлаж байгаа зарим тоололтой таарах, эс таарах эдгээр жишээнээс ургуулан, татан авсан баримтанд тулгуурлан, Бурхан багшийн мэндэлсэн, нирваан дүр үзүүлсэн зэрэг үйл явдлуудыг ёслон тэмдэглэхэд баримтлах өөрийн гэсэн хуучин ёсоо сэргээн мөрдөх нь чухал ач холбогдолтой гэж үзэж байгаа юм.

Энэ бүхний эцэст миний хувьд Лхүндүв бандида, Тэгчэндорж гавж нарыг дагаж, Бурхан багшийн мэндэлсний 2969, нирваан дүр үзүүлсний 2888 жил энэ онд тохиолоо гэж үзэх саналтай байна.

Үгийн далимд, Дашчойнпэл дацанд холбогдох нэгэн мэдээг сийрүүлъя. Тэгчэндорж гавж 1929 онд бичсэн "Шашны зурхай"-даа "Арвангурав дугаар өгүүлэхийн арслан хэмжээлшгүй гарахын орон Дашчойнпэлийн эхийг байгуулж, цагаан зүгтэн нугууд бээр баясал цэнгэлийг дуурсгавай" гарч буй гал хулгана жил нь Нийтийн Тооллын 1756 он бөгөөд эдүгээ 2007 оны нүүр болоход 251 жил болж байна.

Гэвч, энэ жил Дашчойнпэл дацан байгуулагдсаны 270 жилийн ойг нөхөн тэмдэглэсэн учир нь Халхын II богд Лувсандамбийдонмийн үед, Долнуурын газар анхлан хурал байгуулсаныг баримтлан тэмдэглэсэн билээ. Тэр түүхэн цаг хугацаа нь 1736 он болно.

Бидний шийдвэл зохих асуудлууд

Бурханы шашны аливаа ухаан бүр амьтны тус, амгаланг цогцлоохын төлөөх Бурхан, Бодхисадбын их нигүүлсэнгүй сэтгэл, билиг оюуны гэгээ цацрал мөн юм.

Тиймээс зурхайн ухаан тэргүүтнийг зөв зохистойгоор хэрэглэх шаардлагатай байна. Ингэж чадваас тэд жинхэнэ утгаараа нийгмийн өмнө тулгамдсан олон асуудлыг шийдэх гарц болж, хүмүүний нэгэн насны тус бүтэх үүд хаалга болно.

Орчин үед ихээхэн дутагдаад байгаа дотоод сэтгэлийн боловсролыг Бурханы шашны мэдлэг ухааныг таниулах, эзэмшүүлэх замаар иргэн бүрт өгч болно. Ингэсний үр дүнд эрдэнэт хүний амийг бүрэлгэх, хүсээгүй жирэмслэлт нэрээр үр хөндөх гэх мэт гэмт хэрэг, нийгмийн гишүүдийн сахилга бат, ухамсар дорой байгаагаас ихэд түгэн дэлгэрэх хандлагатай болоод байгаа элдэв өвчин тахал тэргүүтэй сөрөг талууд буурч, хүн зоны хэтийн амар амгалан, сайн сайхан гэгч жинхэнэ утгаараа бий болох хөрс суурь нийгэмд бүрэлдэнэ.

Ийм байдалд хүрэхийн тулд мэргэжсэн зурхайч бэлтгэх ёстой болж байна. Үүний тулд сүм хийдийнхэн өөрсдийн дотооддоо зурхайч нэр хүлээлгэн суулгасан лам нараасаа эхлэх нь зохистой. Ингэж эс чадваас өөрсдийгөө зурхайч хэмээн нэрлэж амьтны тусыг эс санан, амин хувийн ашигт хичээгч гудамжны далчин, хөзөрчин, мэргэчингүүдийг цэгцэлж чадахгүй. Уг нь тэд үүн дээр жинхэнэ иргэний зриг зүрх гаргаж, нэг хүний эрх ашиг нийтийн эрх ашгаар хязгаарлагддаг гэдгийг ухамсарлах хэрэгтэй байгаа юм. Нийтийн эрх ашиг бол нэг үндэстний эрх ашиг байх ёстой биз ээ.

Ингэж ухамсарлаж эс чадваас МБШТ тэргүүлэн холбогдох газрууд тэдэнд давтан сургалт, яриа таниулгыг үе шаттай хийж, дахин шалгаж, сүсэгтэнтэй харьцах зэрэгт тодорхой журам гаргаж мөрдүүлэхэд анхаарах нь чухал байна. Нэн түргэн хугацаанд үүнийг хэрэгжүүлэхгүй бол зурхайд итгэх иргэний итгэл үгүй болж, учрыг эс мэдэх, мэдсэн ч үл итгэх мунхагийн балгаар тэдгээр хүмүүс гэм алдасын галт гуунд хөсөр шидэгдэх вий дээ. Ганцхан тэд тийм байдалд хүрээд зогсохгүй, өнөөдөр энэ нөхцөл байдлыг зөвөөр залах боломжтой байсан бүхэн тэднийг "эх болсон амьтанд санаж чадаагүй", "мунхагийн хүлээсээс нь ангижруулахын төлөө арга сүвэгчлээгүй"-нхээ төлөө үйлийн үрийг бас эдлэх болох юм биш үү, сэрэмжлэгтүн!

Мөн олон зууны туршид Буддын шашин дэлгэрч, их бага ухааны орныг судалж, өөрийн гэсэн цаг тооны бичиг зэргийг зохион хөтөлж байсан арвин

түүхтэй үндэстэн мөний хувьд, Бурхан багш нирваан дүр үзүүлээд хэдэн жил болж байгаа вэ гэдэгт өөрийн байр суурьтай байх нь зүйтэй гэж үзэж байна. Юм л бол "Америкт ингэдэг", "Японд тэгдэг" гэх мэтээр бусдыг аялдан дагалдаж, өөрийн гэх үүх түүх, соёл, тархигүй юм шиг хэдий хүртэл явах вэ!

Энэтхэгт Бурхан багшийн нирваан дүр үзүүлсний 2550 жилийн ойг ёслон тэмдэглэхэд, манай хоёр орны найрамдалт харилцааны үүднээс хүндэтгэн хүлээн авах нь зүйтэй ч, эдүгээ тусгаар тогтносон улс мөний хувьд энэ асуудал дээр дотооддоо өөр байр суурьтай байж яагаад болохгүй вэ!

Манай улс төрөөс соёрхон баталсан цаг тооны бичигтэй болох зайлшгүй шаардлагатай байна. Ийм цаг тооны бичигтэй болох боломж бидэнд байна. Урдны монгол номын мэргэд ламын гэгээн Лувсанданзанжанцан, Лхүндүв бандида, Цахар гэвш нараас тасралтгүй дамжиж, өнөө цагийн эрдэмтэн мэргэд Л.Тэрбиш, Зурхайн дацангийн ловон, Гандантэгчэнлин хийдийн шавь Ж.Гончигсүрэн нарын тооцоолон боддог аргыг "монгол газрын хуваарьт тохирсон" гэдэг онцлох шалтгааны улмаас хүлээн зөвшөөрч баталгаажуулахад л бүх асуудлыг цэгцлэх боломж бүрдэнэ.

Энэ мэт элдэв бодол алдаа оноотой байх нь эргэлзээгүй боловч, шашин соёлоо гэсэн иргэн хүний сэтгэлийн үг мөний учир төр болоод шашны эрхэм дээдэс эрх биш тунгаан үзэж, цаашдын бодлого төлөвлөгөөндөө тусган авах нэг боловч хэрэгтэй санаа бий болов уу гэдэг үүднээс их дуугаар ийн өгүүллээ.

Олон мэргэд хүлцэн өршөөж, молхи миний алдас гэмийг уучлан болгоомуй.

НОМ ЗҮЙ

1. Тэгчэндорж "Шашны зурхай" сэдэвт нэргүй бүтээл, гар бичмэлүүд, 1923, 1929 он.
2. Лувсанлхүндүв "Шашны зурхай эрдэнийн эрхи хэмээх оршвой" УБ, 2000 он.
3. Л.Тэрбиш. "Ламын гэгээн Лувсанданзанжанцан, түүний зурхайн бүтээл туурвил" УБ, 2004 он.
4. "Тэнгэрийн утга" Өвөр Монгол хэвлэл,